

8

БАРИЛГА ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны дэргэд 1960 онд их барилгын хэлтэс байгуулагдаж хотын хэмжээнд баригдах барилга байгууламжийн барилга угсралт, хөрөнгө оруулалтын жилийн болон хэтийн төлөвлөгөө боловсруулах түүний биелэлтийг зохион байгуулах чиглэлээр байгуулагджээ.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1969 оны 229 дүгээр тогтоолыг үндэслэн 1971 оны 01.01-нд хотын барилга захиалагчийн товчоо байгуулагдсан. Ажлын хүрээ далайц, эрхлэх ажлын онцлог цаг үеийн хэрэгцээ шаардлагаас шалтгаалан 1990 оноос барилга захиалагчийн товчоо, их барилгын хэлтсийг нэгтгэн Барилга хөрөнгө оруулалтын газар болгон өргөтгөн зохион байгуулжээ.

Энэ нь хөдөлмөрчдийн эрх ашигт нийцсэн, нөгөө талаар орон нутгийн хэмжээнд хөрөнгө оруулалтын замаар хэрэгжүүлэх ажлуудыг төлөвлөх, түүний хэрэгжилтэнд мэргэжлийн байгууллагын зүгээс хяналт тавих боломжийг олгосон нэн чухал арга хэмжээ болсон юм.

Тус газар нь энэ үеэс эдүгээ хүртэл аж ахуйн тооцоон дээр өөрөө өөрийгээ санхүүжүүлэх зарчмаар ажиллаж Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар /чуулганаар/ батлагдсан төлөвлөгөөт зорилтыг ханган биелүүлэхэд анхаарлаа төвлөрүүлж ирлээ.

Үүний үр дүнд сүүлийн 5 жилд тухайлбал 1990 оноос хойш Баянхошууны 150 ортой эмнэлэг, Жаргалантын эмнэлгийн өргөтгөл, Баянхошуу, Шархадны 280 ортой цэцэрлэг, Өлзийт хорооллын сургууль, ХҮ, XXI хороолол, Өлзийт тосгоны цэвэр усны шугам, XXI хорооллын усан сан, Багануурын насос станц, шугамын хамт, Багахангайн цэвэрлэх байгууламж, ХҮ хороолол, Дарь эх, Дамбадаржаа, Өлзийтийн хар замууд, Троллейбусны II ээлжийн шугам, Дамбадаржаагийн гүүр, Баруун уул, XXI хороолол, Хайлааст, Чингэлтэйн үерийн далан, I, XXI, VI бичил хороолалуудад 2079 айлын 75 мян.м² талбай бүхий орон сууцны барилгуудыг ашиглалтанд оруулсны зэрэгцээ жилд сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилгуудад их зарвар хийхэд /жилд 80-210 сая төгрөг/ хяналтыг тавьж ажиллалаа.

Байгууллагын зүгээс ажилтнуудынхаа мэргэжил, боловсролыг дээшлүүлэх зорилгоор компьютер, англи хэл, хууль зүйн талаар мэргэжлийн хүмүүсийг урьж /I-2 сарын сургалтыг байгууллага дээрээ зохион байгуулсны зэрэгцээ 6 хүнийг дотоод гадаадын Бүрст барилгын салбарын зах зээл судлал, замын технологи судлах, барилгын төсөв зохиох чиглэлүүдээр сургав.

Манай байгууллага нь Нийслэлийн бүх дүүргийн нутаг дэвсгэрт хотын захиалгаар баригдаж байгаа шинэ барилга, байгууламж зам, шугам сүлжээ, их засварын ажилд хяналт тавьдаг боловч алслагдсан дүүргүүд тухайлбал Багахангай, Багануурт баригдах барилгуудад хяналт тавих боломж хүндрэлтэй байдаг. Иймд цаашид дүүргүүдэд өөрийн захиалагчийг орон нутгаас нь томилж ажиллуулах нь зүйтэй гэж үздэг.

Төвлөрсөн болон орон нутгийн төсвийн байдал хүндрэлтэй байгааг харгалзан хөрөнгийг нэн чухал барилга байгууламжид төвлөрүүлэхэд анхаарах явдал чухлаар тавигдаж байна.

Энд ялангуяа инженерийн шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, захын хорооллын сургууль, цэцэрлэг, эмнэлгийн үйлчилгээг сайжруулахад анхаарах.

БАРИЛГА ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
Г А З А Р

1999 он

2004-02-26

Ардын хувьсгалын өмнө Нийслэл хүрээний хэргийг эрхлэх засаг захиргаа гэж байсангүй.

1921 оны хувьсгалын дараа Нийслэл хотын амьдралыг удирдан зохион байгуулах үүргийг Дотоод явдлын яам эрхэлж байсан хэдий ч хувьсгалын дараа бий болсон шинэ нөхцөл байдал, зорилт хотод өөрийн захиргаа байгуулахыг зүй ёсоор шаардаж байв. 1924 онд хуралдсан Улсын анхдугаар их хурлаар Нийслэл хүрээг БНМАУ-ын Нийслэлээр тунхаглан Улаанбаатар хот гэж нэрлэсэн дүрмийг баталж, Улаанбаатар хотыг БНМАУ-ын засаг захиргааны бие даасан нэгж болгожээ.

Хотын захиргаа нь Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт төр засгийн тогтоол, шийдвэр, хууль дүрмийг мөрдүүлэх, хотыг хөгжүүлэх зураг төлөвлөгөө гаргах, хотын гудамж талбай, зам, гүүр, цэцэрлэг, судаг хамгаалалт барих тохижуулах, хотыг гэрэл, ус, хоол хүнсээр хангах, худалдаа, зах зээлийн асуудлыг арл олны эрх ашигт нийцүүлж зохион байгуулах, ард олны амгалан тайван байдлыг хангах, соёлжих гэгээрэх эрүүл мэндийг хамгаалах ажлыг үүсгэн зохион байгуулах зэрэг олон чухал арга хэмжээг авч хэрэгжүүлэх салбар чиглэлийн ажил үүрэг хариуцсан байгууллагуудыг байгуулж өөрийн харъяанд аиллуулж ирсэн.

Хувьсгалын өмнө Нийслэл хүрээний үндсэн барилга байгууламж гэвэл хэдхэн тооны модон дугана, мод, шаваран байсан, шургааган хашаа, эсгий гэр байлаа.

Улаанбаатар хотыг шинжлэх ухааны үндэстэй хэтийн төлөвлөгөөтэйгээр хөгжүүлэх, зураг төсөл боловсруулах, барилгын байгууллагуудыг байгуулах, мэргэжилтэй ажилчид бэлтгэх, томоохон үйлдвэр, орон сууцны хорооллуудыг БНХАУ, ЗХУ-ын эдийн засаг техник, мэргэжилтний тусламжтайгаар байгуулах их барилгад хөрөнгө төвлөрүүлэх арга хэмжээг авч эхэллээ.

1953 онд Улаанбаатар хотыг хөгжүүлэх анхны ерөнхий төлөвлөгөө боловсруулан баталж 1953-1980 оны хороонд их барилгад 1006,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж 1, 2 дугаар 40, 50 мянгатын орон сууцны хороолол, Засгийн газрын ордоны өргөтгөл, Улаанбаатар зочид буудал, Төв цэнгэлдэн хүрээлэн, Улсын их дэлгүүрх, Гурилын комбинат, 1, 2 дугаар цахилгаан станц, Чихэр боовны үйлвэр, олон сургууль, цэцэрлэг яслийг барьжээ.

Улаанбаатар хотыг хөгжүүлэх 2 дахь ерөнхий төлөвлөгөө буюу 1961-1975 онд Ш цахилгаан станц, Авто засварын завод, Архи пиво, Хивс, Биокомбинат, Мах консерв, Оёдлын үйлдэрүүд, Улсын клиникийн 1 дүгээр эмнэлэг, Улсын цирк, Телевизийн төв, орон сууцны 5, 12, 15, 19 –р хорооллууд зэрэг соёл ахуйн үйлчилгээний иж бүрэн барилга байгууламжуудыг ашиглалтад оруулжээ. Ингэснээр хотын түлш, эрчим хүч, дулаан, цахилгаан, усан хангамж, радио телефон шугам сүлжээ зэрэг инженерийн барилга байгууламж, зам гүүр, гэрлэн чимэглэл, цэцэрлэгт хүрээлэнг өргөтгөн хөгжүүлэх шинэ шаардлага үүсэн тавигджээ. Үүнээс үндэслэн Улаанбаатар хотыг хөгжүүлэх хэтийн шинэ шинэ төлөвлөгөөнүүд ээлж дараалан батлагдан хэрэгжиж байна.

1976 оноос хойш орон сууцны III, IV, V, I, VI, X, XIII хорооллуудыг соёл ахуйн үйлчилгээний барилга байгууламжийн хамт иж бүрнээр, IV станц, БҮК, гутал,

Ээрмэл, Тэмээ ямааны ноолуурын үйлдвэр, 40 гаруй сургууль цэцэрлэг, бусад олон барилга байгууламжийг барьжээ.

Ийнхүү 1961-1990 он буюу энэ 30 жил нь Улаанбаатар хотыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын он жилүүд байлаа.

1960 –аад оноос аймаг хотуудын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дэргэд байгуулагдсан Их барилгын хэлтэс нь аймаг, хотын хэмжээнд баригдаж байгаа барига байгууламжийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтын ажлыг хариуцан гүйцэтгэдэг байв.

Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дэргэдэх Их барилгын хэлтсийн даргаар н.Бадамжав, н.Лувсан захиалагч инженерээр Даш, Буд, Лхагважав, Сангиринчин, Сүхээ нар ажиллаж байжээ.

Их барилгын хэлтэс нь I, II –40, 50 мянгат, 120 мянгат, XII, ХҮ хороолол, цэвэрлэх байгууламжийн 1 ээлжийг бариулан ашиглалтад оруулж байжээ.

БНМАУ-ын СнЗ-ийн 1969 оны 229-р тогтоолыг үндэслэн Улаанбаатар хотын АДХГЗ-ны 1969 оны 392 тоот тогтоолоор Их барилгын хэлтэс байгуулав. БЗТ –ны даргаар н.Лувсан, инженерээр Мандах, Дорждэрэм, Хуандай, Лхагважав, Лхагвасүрэн, Гүржав, Нацагдорж нар ажиллаж байв.

Тухайн үеийн ажлын шаардлага хөрөнгө оруулалтын хэмжээ өссөнтэй уялдуулан Улаанбаатар хотын АДХГЗ-ны 1970 оны 8 тоот тогтоолоор 1971 оны 1-р сарын 1-нээс Барилга захиалагчийн товчоог байгуулан аж ахуйн тооцоон дээр ажиллуулжээ. БЗТ-ны даргаар 1975-1978 онд н.Мандах, 1978-1982 онд даргаар н.Доржпүрэв, 1982-1990 онд н.Гомбосүрэн нар ажиллаж байжээ.

Нийслэлийн хүн амын хурдан өсөлт, барилгын үйлдвэрлэлийн үсрэнгүй хөгжилтөөс шалтгаалан Барилга захиалагчийн байгууллагын үүрэг хариуцлага, үйлчлэх хүрээг өргөтгөх зорилгоор Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны 1990 оны 109 –р тогтоолоор БЗТ-г татан буулгаж "Их барилга хөрөнгө оруулалтын газар"-ыг байгуулж даргаар нь н.Нэргүйг томилон ажиллуулав. 1992 оны 7-р сарын 1-нээс Барилга хот тохижилтийн газар байгуулан даргаар нь н.Л.Гомбосүрэнг ажиллуулжээ.

"Монгол Улсын Засгийн газрын 178 тоот тогтоолыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Нийслэлийн Засаг даргын 1995 оны 30 дугаар захирамжаар хоттохижилтын ажил Захирагчийн ажлын албаны харъяалалд очсан тул Нийслэлийн засаг даргын 1995 оны 10-р сарын 12-ны А/211 тоот захирамжаар "Барилга хот тохижилтын газар"-ыг өөрчилж "Барилга хөрөнгө оруулалтын газар" болгон дүрмийг нь энэхүү захирамжаар баталжээ. Барилга хөрөнгө оруулалтын газар нь жилдээ 3,0 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалт төвлөрүүлэн 50 шахам баригын гүйцэтгэгч байгууллагатай аж ахуйн гэрээтэй ажиллан нийслэлийн эдийн зэсэн нийгмийн жил жилийн зорилтыг хэрэгжүүлж ирлээ.

Улаанбаатар хотын БХОГ-ыг Захирагчийн ажлын албаны харъяанд ажиллуулах болсонтой холбогдуулан тус газрын даргаар н.Ц.Ганхүүг томилж газрын дүрмийг батлав. /НЗД-ын 1997 оны А/ 179 тоот захирмж/

Тус газар нь Захирагчийн ажлын албаны харъяанд өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар аж ахуйн тооцооны үндсэн дээр Улсын үйлдвэрийн газрын эрхтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байв.

Нийслэлийн засаг даргын 2000-5-25-ны захирамжаар Хөрөнгө оруулалт, хот тохижилтын газар болгон өөрчлөн даргаар нь н.Г. Өлзийг томилон ажиллуулав. Мөн 2001 оны 1-р сарын 1-нээс Хөрөнгө оруулалтын газар болгон даргаар нь Г. Өлзийг томилон ажиллуулсан.

115

Тус байгууллагын архивын 1984 -1999 оны зураг төсөл, техникийн баримт бичигт эрдэм шинжилгээ техник боловсруулалтыг Үндэсний төв архивын мэргэжилтнүүд хийхдээ "Байгууллагын архивын ажлын үндсэн заавар", "ШУТББ-ийг эмхлэн цэгцлэх ажлын заавар"-ыг үндэслэн гүйцэтгэсэн.

Дээрх баримтыг эмхлэн цэгцлэхдээ орон сууц, сургууль цэцэрлэг ясли, эмнэлэг, Инженерийн шугам сүлжээ, хот тохижилт, зам талбай гүүрийн зураг төсөл болон улсын комиссын акт гэж ангилан төрөлжүүлж оны дараалалд оруулсан.

Цэгцлэсний дүнд 1984-2002 оны байнга хадаглах хадагламжийн нэгж 435, түр хадаглах хадагламжийн 130 нэгжид данс үйлдсэн болно.

Монгол улсын засгийн газрын 2003 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 12 дугаар тогтоолоор Хот байгуулалт хөрөнгө оруулалтын газар болгон нэгтгэж дарга бөгөөд Улаанбаатар хотын ерөнхий архитектороор М.Цэлмэгийг томилон ажиллуулсан байна. Байгууллагын архивт Улаанбаатар хотын дэвсгэр зураглалтай холбоотой хадгаламжийн данс шинээр нээж нийт 5 төрлийн данстай болов.

НХБГХГазраас ирсэн нэгж баримтыг архивын сан хөмрөгт оруулан бүртгэж авлаа.

2004 онд бүтцийн өөрчлөлт, шинэчлэлтээр Нийслэлийн Хөрөнгө оруулалт, авто замын газар нэртэйгээр байгуулагдан газрын даргаар Цэлмэгийн томилон ажиллуулж, хэдхэн сарын дараа мөн л өөрчлөлт хийн Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар болон өөрчлөгдсөн ба газрын даргаа Мягмаржавын Цэлмэгийг томилон, 3 хэлтэстэйгээр үйл ажиллагаагаа явуулж ирсэн билээ. Үүнд:

1. Захиргаа аж ахуйн хэлтэс даргаар нь Г.Өлзий

2. Хөрөнгө оруулалтын хэлтэс, даргаар нь Г.Цэрмаа

3. Төслийн хэлтэс даргаар нь Г.Энхтуяа нар тус тус ажиллаж байв. Байгууллагын нийт ажилтануудыг хэлтэсээр нь дурьдвал:

1. Тамгын хэлтэс

- | | |
|----------------|---|
| 1. Г.Өлзий | хэлтсийн дарга |
| 2. Ж.Оюунчимэг | Ерөнхий нягтлан бодогч |
| 3. Я.Болор | хуулийн зөвлөх, хүний нөөцийн мэргэжилтэн |
| 4. Ө.Сүхбаатар | Ерөнхий инженер |
| 5. З.Батцэнгэл | Даргын туслах |
| 6. Н.Бат-өлзий | нярав |
| 7. Ч.Энхтайван | Бичиг хэрэг, архив |
| 8. К.Марат | жолооч |
| 9. Мөнхтөр | жолооч |

2. Хөрөнгө оруулалтын хэлтэс

- | | |
|---------------|------------------|
| 1. Г.Цэрмаа | хэлтсийн дарга |
| 2. Ц.Мэндбаяр | хяналтын инженер |

3. Ё.Долгор хяналтын инженер
4. Л.Гантуяа хяналтын инженер
5. Л.Дугармаа хяналтын инженер
6. Л.Мягмарсүрэн хяналтын инженер
7. Б.Оюунбилэг хяналтын инженер
8. Б.Мөнхбаатар хяналтын инженер
9. Ц.Бүрэнбаясах хяналтын инженер
10. Д.Оюунгэрэл хяналтын инженер

3. Төслийн хэлтэс

1. Г.Энхтуяа хэлтсийн дарга
2. Х.Ариунчимэг хяналтын инженер
3. Э.Түмэндэмбэрэл эдийн засагч
4. Т.Чимэд -Очир Усны инженер нарын нийт 23 хүний бүтэцтэйгээр ажиллаж байсан байна.

Мөн 2005 оны 7 дугаар сарын 1-нд Газрын дарга М.Цэлмэг нь өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн тул даргын үүрэг гүйцэтгэгчээр ерөнхий инженер Ө.Сүхбаатар нь 2006 оны 10 дугаар сарын 16-ны өдөр хүртэл 5 сарын хугацаанд ажиллаж байв.

2006 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын 486 дугаар захирамж, Засгийн газрын 196 дугаар тогтоолоор манай байгууллага нь бүтэцийн өөрчлөлт хийгдэж шинээр Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газар/цаашид БХБТГ/ нэртэйгээр байгуулагдан ажиллаж байна. БХБТГазрын дарга бөгөөд Улаанбаатар хотын ерөнхий архитектороор Нэргүй Нацагдорж томилогдон ирж ажиллаж эхлэв.

Ингээд манай газар нь нийт 48 хүний орон тоотойгоор, 4 хэлтэстэй байгууллага болов. Үүнд:

1.Тамгын хэлтэс

- 1.Г.Өлзий хэлтсийн дарга
2. М.Цэрэндорж Орлогч дарга
3. Ө.Сүхбаатар Ерөнхий инженер
- 4.Ж.Оюунчимэг Ерөнхий нягтлан бодогч
5. Я.Болор Хуулийн зөвлөх, хүний нөөцийн Мэргэжилтэн
6. О.Баярмаа Даргын туслах
7. Н.Бат-өлзий Нярав
- 8.Ч.Энхтайван Архив, бичиг хэргийн эрхлэгч
9. З.Зөвсанаа Даргын жолооч
10. К.Марат жолооч

2. Хот байгуулалтын хэлтэс

1. Ч.Эрдэнэ-Очир хэлтсийн дарга
2. Б.Баяраа БЗД- хариуцсан архитектор
3. Ж.Эрдэнэбат Холбоо, цахилгааны инженер
4. С.Цэнд-Аюуш БГД хариуцсан архитектор
5. Л.Даваажав ЧД хариуцсан архитектор
6. Э.Анар ХУД хариуцсан архитектор
7. О.Одбаяр СХД хариуцсан архитектор
8. Э.Түмэндэмбэрэл Мэргэжлийн комиссын мэргэжилтэн
9. Н.Лхагважав Дулааны инженер
10. Д.Уранцэцэг Газар зохион байгуулагч

- | | |
|------------------|------------------------------|
| 11. С.Болормаа | Газар зохион байгуулагч |
| 12. Т.Чимэд-очир | Усны инженер |
| 13. П.Батчимэг | Хот байгуулалтын эдийн засаг |
| 14. Ц.Хорлоо | СБД хариуцсан архитектор |

115

3. Барилга, хөрөнгө оруулалтын газар

- | | |
|------------------|--|
| 1. Г.Цэрмаа | хэлтсийн дарга |
| 2. Х.Ариунчимэг | хяналтын инженер |
| 3. Ё.Долгор | хяналтын инженер |
| 4. Оргил-Эрдэнэ | хяналтын инженер |
| 5. Л.Дугармаа | хяналтын инженер |
| 6. Л.Мягмарсүрэн | хяналтын инженер |
| 7. Б.Оюунбилэг | хяналтын инженер |
| 8. Б.Мөнхбаатар | хяналтын инженер |
| 9. Д.Оюунгэрэл | хяналтын инженер |
| 10. Т.Болор | Төсөл, төлөвлөлт, газар зохион
байгуулалтын мэргэжилтэн |

4. Хот төлөвлөлт, мэдээллийн хэлтэс

- | | |
|-------------------|------------------------------------|
| 1. С.Төмөрдulam | Хэлтсийн дарга |
| 2. Б.Бумням | мэдээллийн сангийн мэргэжилтэн |
| 3. Ж.Мөнхзул | мэдээллийн сангийн мэргэжилтэн |
| 4. Э.Нандин | Оператор |
| 5. О.Рэнцэндорж | Геодизийн инженер |
| 6. Ч.Цогоо | техникч |
| 7. Д.Дашцэрэн | геодизийн инженер |
| 8. Д.Уранбайгал | Мэдээллийн технологийн мэргэжилтэн |
| 9. Б.Бямбасүрэн | Геодизийн инженер |
| 10. Л.Хан-Уул | Төлөвлөлтийн инженер |
| 11. Н.Эрдэнэцэцэг | Төлөвлөлтийн архитектор |
| 12. А.Амарсанаа | Мэдээллийн технологийн мэргэжилтэн |

нарын нийт 48 ажилтан ажиллаж байна.

Мөн манай байгууллага нь "Их эзэн Чингис хааны хөшөө, Төрийн ёслол, хүндэтгэлийн өргөө"-цогцолборын ерөнхий захиалагч байгууллагаар ажиллаж байгаа ба зургийн ерөнхий архитектороор манай газрын дарга асан Мягмаржав овогтой Цэлмэг ажиллаж, захиалагчийн ерөнхий инженерээр байгууллагын ерөнхий инженер Ө.Сүхбаатар, хяналтын инженер Б.Мөнхбаатар нар байнга барилгын ажлын явц, байдалд хяналт тавин ажиллаж байгаа билээ.

2006.12.31-ний байдлаар Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газрын архив нь нийт 677 нэгжтэй үүнд Байнга хадгалах данс нь 376, түр хадгалах 301 баримттай байна.

Манай байгууллага нь Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газар нь Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд нийслэлийн нутаг давсгэрийн хэмжээнд барилга, хот байгуулалт, дэд бүтэц, газрын харилцааны талаархи хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий ба хэсэгчилсэн төлөвлөгөө, нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах хэрэгжилтэнд нь хяналт тавих, хот байгуулалтын мэдээллийн санг бүрдүүлэх, төвлөрсөн ба нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламж, бусад хөрөнгийн эх үүсвэр бүхий улсын болон нийслэлийн захиалгатай объектын батлагдсан хөрөнгийн зарцуулалт,

шинээр баригдах барилга байгууламжинд тавих техникийн хяналт, үр ашгийг дээшлүүлэх чиг үүрэг, зорилготойгоор ажиллаж байгаа билээ.

116

Манай газрын архивын хөмрөг нь 4 хадгаламжийн нэгжтэй, үүнд байна хадгалагдах данс 1,2,3. Үүнд:

Байнга хадгалгалагдах Данс-1 нь 161 хн-тэй ба энэ баримтууд нь Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын Улаанбаатар хотыг хөгжүүлэхэд хийж буй их бүтээн байгуулалтын ажлын баримтуудыг харж болно. Тус газрын инженерүүдийн 2004-онд ашиглалтанд хүлээн авсан нийслэл Улаанбаатар хотоо хөгжүүлэн цэцэглүүлэхэд хийгдсэн барилгуудын анх улаан шугам тавигдсанаас эхлээд ашиглалтанд орох хүртэл бүх баримтууд хадгалагдаж байна.

Байнга Данс-2 нь нийт 297 хн-тэй үүнд захиргаа, удирдлагын баримтууд, данс-3 нь Налайх дүүрэгт хийгдэж байгаад дуусаагүй цэвэрлэх байгууламжийн баримтууд, данс-4-т тус байгууллагын түр хадгалагдах баримтын бүртгэлүүд тус тус хадгалагдаж байна. өнөөдрийн байдлаар манай газрын архивт 1996 оноос 2006 оны 12 дугаар сарын 31 хүртэл бүрдүүлсэн баримтууд хадгалагдаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 196 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2006 оны 486 дугаар захирамжаар Нийслэлийн Барилга хот байгуулалт, төлөвлөлтийн газар байгуулагдав. Газрын даргаар Нэргүй овогтой Нацагдорж томилогдон ажиллаж байна. Үйл ажиллагааны дүрмээ Нийслэлийн Засаг даргын 2006 оны 527 дугаар захирамжаар батлуулсанг. 4 хэлтэс, 48 хүний орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна. Үйл ажиллагааны дүрэмд өөрөө өөрийгээ санхүүжүүлэх зарчмаар аж ахуйн тооцоон дээр үйл ажиллагаа явуулах бгөөд зайлшгүй тохиолдолд ажилтан авч гэрээгээр ажиллуулж болно гэж заасны дагуу гэрээт 10 ажилтан, үндсэн 48 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.

2007.01.19-ний өдөр шинэчлэн үргэлжлүүлж бичив.

АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ
Ч.ЭНХТАЙВАН